# ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛЬ

ЗАХИРАЛ: Ж.БОЛОРМАА

# АГУУЛГА

1. Суралцагчийн зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагаагзогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй бэлэн байдлыг хангах
2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт хийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах
3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан багш ажлын байранд мэргэжил дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох
4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх
5. Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах
6. Цэцэрлэг сургууль дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших, үйл явцыг дэмжин тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох
7. Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох
8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

**1**

Суралцагчийн зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй бэлэн байдлыг хангах




“Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, цогц төлөвлөгөө” А/190 дүгээр тушаалын хавсралт, Ковид цар тахлын үед сургуультай эргэн холбогдох “Ногоон гэрэл” удирамжийг хэрэгжүүлж, хоцрогдол бууруулж ажиллалаа.




### 1. Сурагчдын судалгаа

- ✓ Байршил, оршин байгаа хаяг
- ✓ Амьдрах орчин, хичээл хийх орчин
- ✓ Утас, дата
- ✓ Сурлагын түвшин




### 2. Багшийн, цахим хичээл сургалт зохион байгуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

- ✓ Ирсэн шийдвэрээс шалтгаалан хичээлэх орчин, хичээлийн хуваарь гарган ажиллах боломжтой.
- ✓ Багшийн цахим хичээл бэлтгэх орчин 100% бүрдсэн
- ✓ Утасгүй интернет сүлжээгээр 100% хангагдсан.
- ✓ Багш нар өөрсдийн боловсруулсан цахим хичээлийн сантай
- ✓ Багш нар цахим бүтээгдэхүүн ашиглах чадварт суралцсан.




### 3. Багш, сурагч, эцэг эхийг холбох, мэдээлэл солилцох цахим орчин бүрдүүлэх

Сургуулийн захиргаанаас байгуулага, ангийн цахим хаягаар мэдээлэл хийх орчин бүрдсэн. Үүнд:

1. Хичээл, сургалт
2. Эрүүл мэнд
3. Хүүхэд хамгаалал
4. Хүмүүжил төлөвшил
5. Нөлөөллийн ажил
6. Танин мэдэхүй

Байгууллагын 2, сургуулийн 60 бүлгийн анги тус бүр сурагч, эцэг эх, багшийг хамруулсан цахим хаягтай






**2**

Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт хийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

Боловсрол шинжлэх ухааны сайдын А/338 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц” - ийг мөрдөн ажиллалаа.

1. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах

2. Сурах хэв маягт хийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах

3. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах



Хөгжийнбэрхшээлтэй сурагч 7




Нийт хоцрогдлын хувь 19,56%

Хоцрогдол бууруулах зорилгоор:

1. Ээлжит хичээлийн чанарыг сайжруулж “Сайн хичээл үйл ажиллагаа” -г 1-12 дугаар ангид 15 удаа зохион байгуулсан.
2. Багш нар хуваарийн дагуу сурагчдад 7 хоногт 40-80 минутын давтлага өгч, ажилласан.
3. Сургуулийн удирдлагууд 85 багшийн хичээлд 100% сууж арга зүйн зөвлөгөө өгсөн.
4. Сургуулийн өөрийн оношлох үнэлгээг 2 удаа /9,3 сард/ авч анализ дүгнэлт хийж, ажилласан. Өөрийн үнэлгээний хувь 48%, 87% үнэлэгдсэн.
5. Багш нар ээлжит хичээлд 1-2 арга зүйг туршин хэрэгжүүлж байна.

Үр дүн: Хоцрогдол 20-40 хувь буурч, сурагчдын унших ойлгох чадварт ахиц гарсан.

Цаашид анхаарах: Багш бүрийн ээлжит хичээлийн чанарыг сайжруулах

Хоцрогдолтой ажиллах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх









**3**

Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан багш ажлын байранд мэргэжил дээшлүүлэх, үр чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох




Сургуулийн шилдэг мэргэжлийн хөгжлийн бүлгээр:
**1 дүгээр байр**: Б.Цэрэнжаргал ахлагчтай "Хичээлийн бүтээлч тэмдэглэл хөтлөх" байгалийн ухааны баг
**2 дугаар байр**" Б.Уранжаргал ахлагчтай "Зорилготой хүүхэд дунд ангийн баг шалгарсан.



Ажлын байран дахь сургалт
- ✓ Сургуулийн менежмент- 2 удаа
- ✓ Хууль бидний ажил, амьдралд
- ✓ Авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх – 4 удаа
- ✓ Цахим сургалт: Zappar, EvalBee программын дадлага сургалт
- ✓ Жендэрийн мэдрэмжтэй харилцаа, хандлага
- ✓ "Хоол боловсруулах эрхтний эрүүл ахуй

Туршлага судлах сургалт, үйл ажиллагаа
- ✓ Сургуулийн менежмент
- ✓ Сургуулийн соёл
- ✓ Хүүхдийн зан төлөвийн судалгаа
- ✓ Харилцаа хандлага
- ✓ Стресс менежмент
- ✓ Сургуулийн сургалт, хүмүүжлийн орчны туршлага судлах




Багш нарт: "Жендэр" эртээ, бүлгийн ажил





Үр дүн
- ✓ Сургуульд судлагдахуунд суурилсан 7, суралцахуйд суурилсан 2 мэргэжлийн хөгжлийн бүлэгт 71 багш хамрагдан асуудлыг шийдвэрлэж ажиллав.
- ✓ Сургуулийн 85 багш 11 удаагийн сургалтад хамрагдсанаар, хууль эрх зүйн мэдлэг, багшлах арга зүй, ур чадварт ахиц гарсан.

# 4

“Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх





“Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ: 2 удаа

1. “Тэргүүлэх зөвлөх багшийн манлайлал” зөвлөн туслах үйл ажиллагаа – 11 сард залуу 22 багшийн хичээлд сууж арга зүйн дэмжлэг үзүүлсэн.
2. “Хүүхэд төвтэй хичээл" 10 хоногийн аяны хүрээнд 5 сард 85 багшийн хичээлд сууж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

| | Судлах хичээл | Багш нарын нэрс | Хичээл заах анги | 5 дугаар сарын 20-31 хооронд Даваа V/20 | Мягмар V/21 | Лхагва V/22 | Баасан V/24 | Даваа V/27 | Мягмар V/28 | Лхагва V/29 | Пүрэв V/30 | Баасан V/31 | Хичээлд сууж ажиглалт хийх, зөвлөн туслах багийн нэр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | Б.Эрдэнэтуяа | 10б | | | | | | | I-6 | | | Я.Алтанцэцэг, Х.Нандинцэцэг, Б.Бямбасүрэн, Б.Энх-Уянга, М.Одмаа. | 5 |
| 2 | | Д.Оюунжаргал | 8а | | | I-6 | | | | | | | Х.Нандинцэцэг, Б.Бямбасүрэн, М.Хэнчбиш Б.Энх-Уянга, М.Одмаа, Ж.Сувдчимэг, Т.Энхтуяа | 4 |
| 3 | | Я.Алтанцэцэг | 8д | | | | | | II-5 | | | | Б.Эрдэнэтуяа Х.Нандинцэцэг, Б.Бямбасүрэн, Х.Ариунтуяа, М.Хэнчбиш, Ц.Хишигээ, Б.Мөнхнаран | 4 |
| 4 | | Л.Энхбат | 7б | | | | II-4 | | | | | | Д.Оюунжаргал, Х.Ариунтуяа, Х.Бямбасүрэн, Г.Оюунбилэг, Ч.Очмаа, Б.Ган-Эрдэнэ | 4 |
| 5 | | Х.Ариунтуяа | 6д | | | | II-3 | | | | | | Д.Оюунжаргал, Х.Бямбасүрэн, М.Хэнчбиш, Я.Алтанцэцэг, Ч.Очмаа, Б.Ган-Эрдэнэ | 5 |
| 6 | | Х.Нандинцэцэг | 9б | | | | | I-3 | | | | | Х.Бямбасүрэн, Б.Эрдэнэтуяа, М.Хэнбиш, Л.Энхбат, Б.Батзаяа, Т.Энхтуяа, Т.Уянга | 5 |
| 7 | | Х.Бямбасүрэн | 6г | | | | | | | II-5 | | | М.Хэнчбиш, Д.Оюунжаргал, Х.Ариунтуяа, Л.Энхбат, Я.Алтанцэцэг | 7 |
| 8 | | М.Хэнчбиш | 11б | | | I-5 | | | | | | | Х.Бямбасүрэн, Х.Нандинцэцэг, Л.Энхбат, Ц.Хишигээ, Ж.Сувдчимэг | 5 |
| 9 | [illegible] | Б.Бямбасүрэн | 11а | | | | I-2 | | | | | | Б.Мөнхнаран, Г.Оюунбилэг, Т.Гэрэлмаа, Ө.Гантуяа | 5 |
| 10 | | Т.Уянга | 7в | | | | II-5 | | | | | | Ө.Гантуяа, Г.Оюунбилэг, Б.Ууганцэцэг, Ц.Хишигээ | 5 |
| 11 | | Б.Мөнхнаран | 9а | | | | I-7 | | | | | | Б.Бямбасүрэн, Б.Батзаяа, Б.Ууганцэцэг, | 5 |
| 12 | | Г.Оюунбилэг | 9г | | | | | I-2 | | | | | Т.Уянга, Б.Мөнхнаран, Ж.Сувдчимэг, Г.Азаяа, Б.Бямбасүрэн | 5 |
| 13 | | Т.Гэрэлмаа | 12а | | | I-3 | | I-6 | | | | | Б.Батзаяа, Х.Ариунтуяа, Т.Уянга, Ж.Сувдчимэг | 4 |
| 14 | | Ө.Гантуяа | 9г | | | | | I-2 | | | | | Т.Гэрэлмаа, Б.Батзаяа, М.Одмаа, Б.Эрдэнэтуяа, | 4 |
| 15 | | Б.Батзаяа | 11а | | | | I-2 | | | | | | Ц.Хишигээ, Б.Ууганцэцэг, Т.Энтуяа, Ө.Гантуяа | 5 |
| 16 | | Ц.Хишигээ | 7а | | | | II-7 | | | | | | Т.Гэрэлмаа, Ө.Гантуяа, Ж.Сувдчимэг,Б.Ууганцэцэг, Б.Мөнхнаран, Т.Энхтуяа | 5 |
| 17 | | Бд.Ууганцэцэг | 8а | | | | | | | | I-5 | | Б.Батзаяа, Д.Октябь, Б.Энх-Уянга, Т.Гэрэлмаа, Т.Энхтуяа | 5 |
| 18 | | Т.Энхтуяа | 12б | | | | | I-6 | | | | | Б.Ууганцэцэг,Ц.Хишигээ, Б.Батзаяа, Б.Бямбасүрэн, Т.Уянга | 4 |
| 19 | | Ж.Сувдчимэг | 6д | | | | | | | | II-4 | | Г.Оюунбилэг, Б.Мөнхнаран, Т.Уянга, Х.Баттуяа, Д.Октябрь | 5 |
| 20 | [illegible] | Ч.Очмаа | 8б | | | | II-2 | | | | | | Д.Октябрь, Б.Ган-Эрдэнэ, Д.Туяа, Б.Болормаа, Х.Баттуяа, | 4 |
| 21 | [illegible] | Д.Октябрь | 7б | | | II-5 | | | | | | | Ч.Очмаа, Г.Азаяа, Д.Туяа, Б.Болормаа, Х.Ариунтуяа, Х.Нандинцэцэг, Б.Энх-Уянга | 4 |
| 22 | [illegible] | Б.Энх-Уянга | 6а | | | | | | | II-3 | | | Х.Баттуяа, Н.Азаяа, Б.Болормаа, Д.Туяа, Я.Алтанцэцэг, Л.Энхбат, Д.Оюунжаргал | 4 |
| 23 | | Б.Ган-Эрдэнэ | 8г | | | | | | | | II-2 | | Б.Энх-Уянга, М.Одмаа, Ц.Хишигээ, Г.Оюунбилэг, Х.Баттуяа | 4 |
| 24 | [illegible] | Г. Азаяа | 8г | | | | I-2 | | | | | | М.Одмаа, Б.Эрдэнэтуяа, Б.Бямбасүрэн, | 5 |
| 25 | | Х.Баттуяа | 10а | | | | I-4 | | | | | | М.Одмаа,Д.Октябрь, Ч.Очмаа, Б.Бямбасүрэн, Б.Мөнхнаран, Б.Эрдэнэтуяа | 4 |
| 26 | | М. Одмаа | 8б | | | II-3 | | | | | | | Г.Азаяа, Б.Ган-Эрдэнэ, Д.Туяа, Б.Болормаа, Д.Оюунжаргал | 5 |

Үр дүн:

Тус сургуульд зөвлөх зэрэгтэй 3, тэргүүлэх зэрэгтэй 15 багш хичээлд сууж ажиглалтын хуудсаар 1-4 дүгээр түвшинд үнэлэн, арга зүйн зөвлөгөө өгсөн ба заах аргач 23 багш болон зэрэггүй багш нар 4-5 багшийн хичээлд сууж, арга зүй, ур чадварын туршлага судлав.

Ахмад багшийн зөвлөх үйлчилгээ: Хичээлийн жилийн турш

Зөвлөх багш Захирал Ж.Болормаа, Г.Цэрмаа, Б.Байгалмаа, ахмад багш Д.Туяа, Б.Өлзиймаа, Б.Хүрэлбаатар, Д.Оюунжаргал, Б.Болормаа, Г.Ганчимэг багш нар 11 залуу багшид “Зөвлөх үйлчилгээ”-г үзүүлж, анги удирдах урлаг, мэргэжлийн хичээлийн заах арга зүйд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.





Шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх: 3 удаа

1. Сургалтын менежерийн өдөрлөгөөр “Сургуулийн менежментийн хэрэгжилт” туршлага сургалтын менежер А.Баярмаа, Б.Уранжаргал, Ш.Алтантуяа
2. “Сургуулийн менежментийн хэрэгжилт” цахим туршлага олон нийтэд БШУГ, сургуулийн цахим хуудсаар
3. Сургуулийн менежментийн хэрэгжилт” сургуулийн 26 захирлуудад захирал Ж.Болормаа
4. “Эцэг эхийн тайлант өдөрлөг”-өөр 4 өртөөгөөр сургалт, хүмүүжил, оролцооны байгууллага, анги удидсан багшийн үйл ажиллагааг СНА Д.Ганчимэг, сэтгэл зүйч Б.Өлзийжаргал нар

Үр дүн:

✓ Сургуулийн менежментийн хэрэгжилт үйл ажиллагааг сургуулийн удирдлага, эцэг эх олон нийтэд түгээн дэлгэрүүлж ажилласан.

# 5

Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Багш, ажилтан, албан хаагчдын дунд албан байгууллагын нийгэм-сэтгэл зүйн байдлыг үнэлэх зорилгоор “Хөдөлмөрийн хамт олны нийгэм сэтгэл зүйн уур амьсгал”, “Копенгагений ажлаас халшрах хам шинж”, “Асуудалд хэрхэн ханддаг, асуудлыг яаж шийдвэрлэдэг байдал”-ыг тодорхойлох тестүүдийг авч, боловсруулалт хийсэн.







Албан байгууллагын нийгэм-сэтгэл зүйн уур амьсгалыг дэмжих зорилгоор бүлгийн сэтгэл зүйн тренингийг нийт 93 багш, ажилчдын дунд хичээлийн 2 дугаар улирлын амралтаар зохион байгуулсан. Ажлын бүтээмж, эрч хүчийг нэмэгдүүлэх зорилгоор Candy party үйл ажиллагааг хичээлийн жилийн эхэнд 9 сард зохион байгуулсан.





Шинээр ажилд орсон, ажилласан жил багатай залуу 9 багш, ажилчдад ажилдаа дасан зохицох, асуудал бэрхшээлийг даван туулах зорилгоор бүлгийн зөвлөгөө зохион байгуулсан.



Багш, ажилтан, албан хаагчдад хүүхэдтэй харилцах арга барил, хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүй, нийгэмших үйл явцын онцлог зэрэг сэтгэл зүйн боловсрол олгох зорилгоор нийт 83 багш, ажилчдад “Сэтгэл зүйн нөлөө ба сурах танин мэдэх” сэдвийн хүрээнд сургалт, зөвлөгөө зохион байгуулсан.



Стресс, цагийн менежмент, гэр бүл болон ажлын орчны харилцааны бэрхшээл зэрэг асуудлаар ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг нийт 6 багш, ажилтанд өгч нийт 10 удаагийн уулзалт хийсэн.

# 6

Цэцэрлэг сургууль дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших, үйл явцыг дэмжин тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

"Бид дээрэлхэлтээс ангид байя", "Найзыгаа би гадуурхахгүй", "Электрон тамхины хор уршиг" гэсэн сэдвүүдээр РР бэлтгэн 9-12 дугаар ангийн дарга нарыг ангийн багштай хамтран сургалт зохион байгуулж, сургалтанд хамтрагдсан сурагчдын бүртгэл мэдээлэл, зурган тайланг нэгтгэн авч ажилласан. Нийт 12 бүлгийн 480 сурагчид сургалтанд хамрагдсан байна.

2023.10.11нд. ЦГ-т 10,11 ангийн нийт 145 хөвгүүдэд хүүхдийн байцаагч дэслэгч Ганзориг, ахмад Мөнхтөр нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. Сургуулийн нийгмийн ажилтан Д.Ганчимэг 10а ангийн багш Г.Цэрмаа, 10д ангийн багш Л.Болорцэцэг нартай хамтран зохион байгуулсан.




Сургуулийн эцэг эхийн зөвлөлийн санаачлагаар бага сургуульд 13 ширхэг камер, ахлах сургууль дээр 13 ширхэг нийт 26 камер гадаад дотоод орчинд байршуулж, хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах нөхцлийг бүрдүүлэн, сургуулийн хяналтын камер ашиглах журам боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн сургуулийн аюулгүйн зураглалыг шинэчилж гаргасан. АУБ бүр ангийн сурагчдаар аюулгүйн зураглал гаргаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байна.




9-10 сард

Нийгмийн ажилтан 6-12 дугаар ангийн нийт 34 ангийн дарга нарыг чиглүүлэн ажиллаж байна. Долоо хоног бүрийн Даваа гаригт ангийн дарга нартай, хийсэн ажил дээр нь дүгнэлт гарган цаашид хийх, анхаарах ажлуудаа ярилцаж, зөвлөгөө өгч ажилладаг.



11-12 сард

Ахлах ангийн 12 дугаар ангийн 16 хөвгүүдэд "Электрон тамхины хор уршиг", "Гэмт хэргээс хол бай" сургалт мэдээллийг нийгмийн ажилтан Д.Ганчимэг, ахлах ангийн менежер А.Баярмаа нар хамтран зохион байгуулсан. Энэ сургалт мэдээллийн үр дүнд дүү нартаа үлгэр дуурайлал болох нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.



1-2 сард

"Хүүхэд хамгааллын журам"-ын талаар 10 дугаар ангийн нэгдлийн хуралд нийгмийн ажилтан мэдээлэл өгсөн.Нийт 84 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан.




3-4 сард

5-6 сард

Сургуулийн гадаад, дотоод орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн ХААБ, Дотоод хяналт, Хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнтэй орчны эрсдэлийн үнэлгээг 2023.10.12 нд, 2024.04.05 нд жилд 2 удаа зохион байгуулж хийсэн. Хангалтгүй үнэлэгдсэн засан сайжруулах шаардлагатай дүгнэлтийг холбогдох нэр бүхий хүмүүст танилцуулан хугацаа зааж засан сайжруулсан.





# 7-1

Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Гүйцэтгэлийн үнэлгээний сэтгэл ханамжийн үнэлгээ, эрсдэлийн өөрийн үнэлгээний үр дүн, багш, сурагчдаас гарсан саналын мөрөөр дараах үйл ажилагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

### Сурагчдын ариун цэврийн өрөө

Хаалт, хогын сав, почки
Эцэг эхийн зөвлөл- 3,000,000
Сургуулийн захиргаа 5,790,800

### Хөгжлийн бэрхшээлтэй Хүүхдийн 00, бариул хаалга

Бариул-380,000
Хаалга, Суултуур, алхуулагч -540,000

### Охидын ариун цэврийн хэрэгслийн хайрцаг

Эцэг эхийн хандиваар









## 7-2

Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Гүйцэтгэлийн үнэлгээний сэтгэл ханамжийн үнэлгээ, эрсдэлийн өөрийн үнэлгээний үр дүн, багш, сурагчдаас гарсан саналын мөрөөр дараах үйл ажилагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

### Бага сургууль ажилчдын өрөө

Хаалга, битүүмж, бусад-336,000 төгрөг

### Гадна хогын сав

Материал- 2500,000 төгрөг

### Санамж, зөвлөмж

Унтраалга, залгуур, хүүхэд хамгаалал, ариун цэврийн мэдээлэл, гарц тэмдэглэгээ










**7-3**

Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Гүцэтгэлийн үнэлгээний сэтгэл ханамжийн үнэлгээ, эрсдэлийн өөрийн үнэлгээний үр дүн, багш, сурагчдаас гарсан саналын мөрөөр дараах үйл ажилагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

**Мэдээлэл зүйн кабинет**

“Бичил глобус” ББСБ - 10,000,000,
Сургуулийн захиргаа - 2,000,000 төгрөг

**Эрэгтэй технологийн кабинет**

Хулдаас - 800,000
Засвар -1500,000

**Хүүхэд хөгжлийн танхим**

Эсгий хавтан, засварын материал – 1,200,000







**7- 4**

Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Гүцэтгэлийн үнэлгээний сэтгэл ханамжийн үнэлгээ, эрсдэлийн өөрийн үнэлгээний үр дүн, багш, сурагчдаас гарсан саналын мөрөөр дараах үйл ажилагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

Миний хэлэх дуртай үг мэдээллийн орчин

Хаягдал акустик ашиглан хийсэн

Сурагчдын бүтээлийн орчин

Солигдож мэдээлэл Хуваалцах орчин

Багш сурагчдын мэдээллийн самбар

Хүмүүнлэгийн ухааны багш нарын Мэдээллийн самбар 1,000,000 төгрөг













8-1

Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

## БҮСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Бүсийн сургалт








"Сургуулийн менежмент, хамтын оролцооны үр дүн" бүсийн сургалтыг 85 багш, удирдлага, нийгмийн ажилтныг хамруулан зохион байгуулж, хамтран суралцсан.

2. Бүсийн нэгж хөтөлбөрийн уралдаан









“Бүсийн нэгж хөтөлбөрийн уралдаан”-ыг 2024 оны 04 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд, сургалтын менежер, мэргэжлийн багшийн өөрийн удирдлагатай амжилттай зохион байгууллаа.
Үр дүн: Уралдаанд 5, Шинэ хөгжил, 2 дугаар сургууль, Чойбалсан, Чулуунхороот сумын сургуулиудын 13 судлагдахууны 47 хөтөлбөр хэлэлцэгдэж, хөтөлбөрийн сантай болсон.

3. Бүсийн “ Сайн хичээл, хамтын үйл ажиллагаа”





Бүсийн сургуулийн багш нарын “ Сайн хичээл хамтын үйл ажиллагаа”-г 2024 оны 12 дугаар сард зохион байгуулж, бүсийн, аймгийн төвийн 3 сургуулийн бага, дунд ангийн монгол хэл, биологи, хими, физик, газарзүй, орос хэл, англи хэлний багш нар 5 дугаар сургуулийн 13 хичээлд сууж хамтран ажиллалаа.
Үр дүн: Хичээл ажиглаж буй багш нарт сургуулийн менежментийн чиглэлийн хүрээнд Боловсролийн ерөнхий газрын боловсруулсан “Хичээл ажиглах хуудас”-ыг танилцуулан, ээлжит хичээлд сууж, ажиглан, засан сайжруулалт хийж, туршлага түгээсэн. Үйл ажиллагаанд нийт бүсийн 46 багш хамрагдсан.

Бүсийн удирдлагуудын уулзалт, хэлэлцүүлэгийг 9, 4 сард танхим болон цахимаар хийж, хамтын ажиллагааг хэлэлцэн, дүгнэсэн

# 8-2

Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

## БАГШ, СУРАГЧИЙГ ДЭМЖИХ, ТУРШЛАГА ТҮГЭЭХ

### 1. “Сайн туршлага-One page” уралдаан

























Багш нар хүүхдийн хөгжил болон суралцахуйд тулгамдсан асуудлыг хамтын оролцоотой шийдвэрлэх, сайн туршлага түгээх, харилцан суралцах зорилготой сургуулийн “САЙН ТУРШЛАГА-ONE PAGE” уралдааныг 4 сарын 20-ны өдөр зохион байгулав.

Үр дүн: Үйл ажиллагаанд 6 багийн 20 багшийн ганцаарчилсан болон мэргэжлийн хөгжлийн бүлгийн сайн туршлага хэлэлцэгдэж, түгээн дэлгэрүүлсэн.

### 2. “Сурагч багш” цахим хичээлийн уралдаан





5 сард “Сурагч багш” цахим хичээлийн уралдааныг 10-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Уралдаанд 26 сурагч хамрагдан, цахим хичээл зааж, шалгарсан 3 сурагчдыг “Эрдмийн баяр”-аар шагнаж урамшуулсан.

Үр дүн: Сурагч, сурагчдаа ойлгоогүй агуулгыг заасан нь өөрөө сурч мэдэх бусдадаа нөлөөлөх зэрэг ололттой байсан. Цаашид уламжлал болгон зохион байгуулах санал сурагчдаас олноор ирсэн.

Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

## ХҮМҮҮЖИЛ ТӨЛӨВШИЛ, ЭРҮҮЛ МЭНД

### 1. “Зорилготой хүүхэд”





Дунд ангийн 20 бүлгийн 792 сурагчдад дэг соёлыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх зорилгоор “Зорилготой хүүхэд” дэвтрийг хөтлүүлж байна.
Үр дүн: Дэвтрийг хөтөлснөөр:

1. Сурах идэвх оролцоо сайжирсан 357 сурагч буюу 45%
2. Зөв дадал хэвшилд суралцаж, ахиц гарсан 132 сурагч 16%
3. Эрүүл мэнд: Усны сав авч явдаг болсон 425 сурагч 53,6%
   Биеийн тамирын хичээлийн дараа цэвэр оймс сольж өмсдөг болсон 693 сурагч, 87,5%

### 2. Эрүүл шүд



БОЭТ-н шүдний кабинеттай хамтран сургуулийн нийт 2158 сурагчдыг шүдний үзлэгт хамруулсан ба 1320 эрүүл, 838 хүүхэд өвчлөлтэй гарсан. Эрүүл 805 хүүхдэд шүдний цоорол болон эрдэсжүүлэх фторт түрхлэг түрхсэн. Өвчлөлтэй 1320 хүүхдээс 6-8 дугаар ангийн 213 сурагчдыг сонгон БОЭТ-ийн шүдний кабинеттай хамтран, эмчилгээ хийж амны хөндийг эрүүлжүүлсэн. Эмчилгээ хийх явцад 5-6 шүдний эмчилгээг 1 дор хийж байлаа. Үлдсэн сурагчдын эцэгт эхэд шүдний өвчлөлийн мэдээлэл өгч, шүдийг эрүүлжүүлэх зөвлөгөө өгсөн.

1 дүгээр ангийн сурагчдын шүд угаах орчин бүрдүүлж, угааж хэвшсэн.

Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ

## ДОТООД НӨӨЦӨӨР ОРЧНЫГ ТОХИЖУУЛАХ

1. “Сурагчдын чөлөөт орчин”








2. “Бага сургуулийн номын сан”





# Цаашид анхаарах асуудал



1
Гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод хяналт, саналд үндэслэн асуудлаа тодорхойлох

2
Багшийн ээлжит хичээлийн чанар, үр дүнг сайжруулах

3
Эцэг эхийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх

4
Хүүхдийн сурч хөгжих орчинг, хамтын оролцоотой бүрдүүлэх

5
Мэргэжлийн хөгжлийн бүлгээр, асуудлыг шийдвэрлэж ажиллах

Анхааран сонссонд баярлалаа